

**МОНГОЛ УЛС, ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК
ХООРОНДЫН “ЭРЧИМ ХҮЧ-4 ТӨСӨЛ”-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН
ТӨСЛИЙГ ТӨСВИЙН БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХАМТАРСАН ХУРАЛДААНААР ЗӨВШИЛЦСӨН
ТАЛААРХ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийг үндэслэн Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороод 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэгт заасны дагуу зээлийн хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хороо урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлснийг нэгтгэн хэлэлцсэн.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар дээрх төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын “Эрчим хүч-4 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж, төслийн техник, эдийн засгийн үндэслэл бэлэн эсэх болон уг төсөл хэрэгжиж дуусгах боломжит хугацааны талаар тодруулж, Бүгд Найрамдах Солонгос Улсын Экзим банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх 10 аймгийн дулааны станц барих төслийн хэрэгжилттэй адил нөхцөл байдал үүсгэхгүй байхад анхаарах нь зүйтэй бөгөөд төслийн бүтээн байгуулалтын ажилд дотоодын аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой эсэх талаар,

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат “Эрчим хүч-4 төсөл”-ийг үр дүнтэй, үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд анхаарах, төслийг хэрэгжүүлснээр Монгол Улсын Засгийн газрын нийт өр, гадаад зээлийн өрийн үлдэгдэл, хүү, зээлжих зэрэглэл өөрчлөгдөх эсэх, мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын Экзим банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх 10 аймгийн дулааны станц барих төслийн зээлийн ашиглалтын явцын талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 дахь заалтын дагуу энэ төслийн талаар олон нийтэд мэдээлсэн эсэх, Монгол Улсын Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн байдал, Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл, гадаад зээлийн ашиглалт, зээлийн үйлчилгээний төлбөрийн талаар, цаашид төлбөрийн болон төсвийн тэнцэлд дарамт үүсгэхгүй байхад анхаарсан төсвийн бодлогыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн эсэхийг асууж, хариулт авлаа.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал зээлийн хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж, төслийг бүрэн дуусгаж, түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр хэрэгжүүлэхэд анхаарч, төсөл дуусгавар болоогүй тохиолдолд хүүгийн төлбөрийг хэн төлөх зохицуулалтын талаар зээлийн хэлэлцээрийн төсөлд тусгах, мөн төслийн зээлийн эх үүсвэрийн хуваарилалтыг хэрэгжүүлэх ажлын графиктай уялдуулах, гадаад зээлээр хэрэгжүүлэх төслүүдийг эдийн засгийн үр ашигтай байдлаар нь эрэмбэлэх, өөрийн орлогоороо зардлаа нөхөх боломжтой

төслүүдийн ашиглалтын хэмжээг Засгийн газрын нийт өрийн хэмжээнд тусган Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан хэрэгжүүлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр Бүгд Найрамдах Солонгос Улсын Экзим банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн гэрээтэй адил чанаргүй гэрээг хийхгүй байхад анхаарах, төслийг гэрээний хугацаанд дуусгах нь зүйтэй талаар,

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг зээлийн хэлэлцээрт тусгагдсан зээлийн ашиглалтыг сайжруулахад анхаарах, цаашид Үндэсний баялгийн сангаар эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлж, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд төслөөс хувьцаа хэлбэрээр үр өгөөж хүртдэг байх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн гадаад зээл, тусламжийн бодлого, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэхэд анхаарах, зээлийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлтийг оновчтой хийдэг байх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат эрчим хүчний төслүүдийг гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нь зүйтэй гэж, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасны дагуу эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангахад шаардагдах санхүүжилтийн хэмжээ болон гадаадын зээлээр хэрэгжүүлэх эрчим хүчний төслүүдийн зээлийн дүн нь уг хэрэгцээтэй байгаа санхүүжилтийн хэдэн хувийг хангах боломжтой талаар тооцоолол хийдэг байхад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн талаар дурдаж, цаашид төсвийн төлөвлөлт, тооцооллыг бодитоор хийж, гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулах нь зүйтэй талаар үг хэлсэн болно.

Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн 67.7 хувь буюу олонх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын "Эрчим хүч-4 төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгов.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН